

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛООР БАТАЛСАН ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВРЫН ЖАГСААЛТ**

2017.11.03

Арвайхээр

Д/д	Шийдвэрийн тэргүү	Дугаар	Шийдвэрийн агуулга	Тайлбар
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2012				
1.	Хөтөлбөр батлах тухай	25	Хүмүүнлэгийн хөтөлбөр: Төрийн хүмүүнлэгийн бодлогын хүрээнд аймаг орон нутгийн төр захиргааны байгууллага, Улаан загалмайн хорооны хамтын ажиллагааг нэгдмэл байдлаар оновчтой зохион байгуулж орон нутгийн иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, төрөөс үзүүлж буй нийгмийн халамжинд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, хүмүүнлэг энэрэнгүй шударга ёсны зарчмыг сурталчлан дэлгэрүүлэх	
2.	Журам батлах тухай	31	Малжуулах сангийн журам: орлого багатай малчин өрхийг дэмжих, орлогыг нэмэгдүүлж амьжиргааг сайжруулах	
3.	Журам батлах тухай	42	Ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх сангийн журам: Ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулах	
4.	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үүсгэн байгуулах, түүний дүрэм батлах тухай	44	Өвөрхангай аймгийн эмийн эргэлтийн сангийн дүрэм	
5.	Журам батлах тухай	46	Аймгийн тусгай хэрэгцээний газраас газар чөлөөлөх, хайгуулын үр дүнг тооцох журам: аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, эрдэс баялагийг зохистой ашиглах, байгалийн баялагийн үр шимийг иргэд олон түмэнд жигд хүртээх, нөхөн сэргээх ажлыг сайжруулах	
6.	Журам батлах тухай	101	Дугуй хөрөө ажиллуулах журам: иргэн, ААН, байгууллагын хэрэглээний бөөрөнхий мод, гуалинг боловсруулж зүсмэл материал үйлдвэрлэх зорилгоор ашиглах дугуй хөрөө ажиллуулахтай холбогдож үүсэх харилцааг зохицуулах	
7.	Журам батлах тухай	122	Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, зарцуулах, зохион байгуулах, тайлагнах журам: орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, иргэдээр хэлэлцүүлэг хийлгэх, зарцуулах, зохион байгуулах, тайлагнах, гүйцэтгэлд хяналт тавих	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2013				
8.	Дүрэм батлах тухай	19	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дүрэм	
9.	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай	33	Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр /2013-2018/: хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж агаар, орчныг адиваа	

			бохирдлоос хамгаалах бодлого, үйл ажиллагаа явуулж, Арвайхээр хотын агаарын бохирдлыг одоогийн байгаа түвшингээс бууруулах арга хэмжээг цогцоор шийдвэрлэх	
10.	Журам батлах тухай	35	Ажил олгогчийг урамшуулах журам: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, шинэ ажлын байр олноор бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах	
11.	Дэд комисс шинэчлэн байгуулах тухай	38	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд комиссын журам: ЖДҮ-ийг санхүүгийн талаар дэмжих арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах аймгийн дэд комиссын үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулах	
12.	Салбар хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, дүрэм, ажлын төлөвлөгөө батлах тухай	39	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн салбар хорооны дүрэм	
13.	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2013-2017 онд хөгжүүлэх бодлого батлах тухай	40	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2013-2017 онд хөгжүүлэх бодлого: эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг байршуулах, давтан сургах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах тогтолцоог сарлбарын хэрэгцээтэй уялдуулан зөв зохистой зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтний үр чадвар, ёс зүйг эрхэмлэн дээдэлсэн эмч эмнэлгийн мэргэжилтнээр хангах	
14.	Гэр хорооллын стандарт батлах тухай	50	Гэр хорооллын стандарт: аймгийн сум суурин газарт гэр хороолол байгуулах, одоо байгаа гэр хорооллыг тохижуулах замаар ард иргэдийн амьдрах орчныг сайжруулах	
15.	Шалгуур үзүүлэлт батлах тухай	53	Аймгийн "Жишиг сум"-ын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт: 2 жилд 1 удаа шалгаруулах	
16.	Журам батлах тухай	55	Аймгийн ИТХ-ын албан томилолт олгох журам: албан томилолтын зардалд хяналт тавьж, үр ашиггүй томилолтыг багасгах, гүйцэтгэх ажил үүргийн чанар үр дүнг сайжруулах	
17.	Журам шинэчлэн батлах тухай	65	Тэргүүлэгчдийн ажил дүгнэх, урамшуулал олгох журам: Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, тэдний үйл ажиллагааг тогтмол үр дүнтэй явуулах, гүйцэтгэж буй үүрэг хариуцлагыг сайжруулах зорилгоор ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгох	
18.	Тэргүүлэгчдийн хуралдааны дэг батлах тухай	74	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэг	
19.	Нэрэмжит шагнал бий болгох тухай	76	Л.Гомбосүрэнгийн нэрэмжит шагналын журам: Орон нутгаа хөгжүүлэхэд санаачлага гарган амжилтанд хүргэсэн Засаг дарга, иргэн, аж ахуйн нэгжийг шагнах	
20.	Журам шинэчлэн батлах тухай	83	Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох журам	
21.	Дүрэм батлах тухай	86	Аймгийн ИТХ-ын дэргэдэх ИМҮТөвийн дүрэм	
22.	Агнуурын бүс нутаг тогтоох	89	Аймгийн агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах зорилгоор	

	тухай		Өшгөгийн нуруу, Бага богдын нуруу, Зүүнхайрхан, Дөлгөөн уулын тодорхой талбай бүхий газрыг агнуурын бүс нутаг болгосон.	
23.	Журам, гэрээний үлгэрчилсэн загвар, түрээсийн төлбөрийн доод үнэ батлах тухай	93	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээд хөрөнгө түрээслэх журам, Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх гэрээ, Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам, Орон нутгийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн журам, Орон нутгийн өмч ашигласны төлбөрийн хэмжээ	
24.	Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, уяач, спортын хороодыг урамшуулах журам батлах тухай	95	МУ-ын Биеийн тамир спортын тухай хуулийн 22.1.1, 22.1.2, 22.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн аймгаас спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, уяач, спортын хороодыг мөнгөн шагналаар урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулах	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2014				
25.	Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ байгуулах тухай	09	Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрэм	
26.	Хөтөлбөр батлах тухай	15	Архидалтгүй-Өвөрхангай хөтөлбөр /2014-2017/	
27.	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай	20	Иргэний боловсрол хөтөлбөр /2014-2018/: Иргэн бүр нийгмийн хөгжлийн чиг хандлага болон хувь хүний эрх ашигт нийцсэн боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмшиж, амьдралынхаа чанарыг дээшлүүлэхэд шаардлагдах боловсролыг ахиулахад оршино.	
28.	Шагналын журамд өөрчлөлт оруулах тухай	24	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгох шагналын журамд өөрчлөлт оруулах тухай	
29.	Журамд өөрчлөлт оруулах тухай	33	Хүүхдийн хууль зүйн хорооны дүрэм, ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай	
30.	Журам батлах тухай	37	Иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэхэд баримтлах журам	
31.	Журам батлах тухай	38	Нутгийн удирдлагын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам	
32.	Журам батлах тухай	42	Хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмжийг ашиглуулах журам	
33.	Төлбөр тогтоох тухай	58	Зам, гүүр, үерийн даланд ашиглагдах дүүргэлтийн шороонд төлбөр тогтоосон	
34.	Журам батлах тухай	63	Иргэний хяналтын багийн ажиллах журам: Төрийн болон оронн утгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлд иргэний хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах	
35.	Хөгжлийн хөтөлбөр батлах тухай	70	Өвөрхангай аймгийн ХДТ-ын хөгжлийн хөтөлбөр: Төв Халхын өв соёлыг дэлхийн соёлтой жишиглэн хөгжүүлж, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн урлагийн байгууллагыг хөгжүүлэх.	
36.	Журам батлах тухай	71	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох	

			журам	
37.	Зүүн хайрхан уулыг аймгийн тахилгатай болгох тухай	89	4 жилд нэг удаа тахих	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2015				
38.	Төв суурин газрын хог хаягдлын жишиг норматив, төлбөрийн хэмжээг тогтоох тухай	08	Төв суурин газрын хог хаягдлын жишиг норматив, төлбөрийн хэмжээг тогтоосон	
39.	Ажлын цагийн хуваарь шинэчлэн батлах тухай	18	Ажлын цагийн хуваарь шинэчлэн баталсан	
40.	Журамд өөрчлөлт оруулах тухай	25	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам	
41.	Ус ашиглах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай	34	Ус хэрэглэгч, ашиглагчтай гэрээ байгуулах, эрхийн бичиг олгох, гэрээ сунгах, рашаан ашиглах, савлах, зөвшөрөл олгох	
42.	Ус хангамж, ариутгах татуургын хамгаалалтын бүс тогтоох тухай	36	Арвайхээр сумын төвлөрсөн ус хангамжийн төв усан сангийн эрүүл ахуйн хамгалалтын бүс тогтоох	
43.	"Стандарттай Өвөрхангай" хөтөлбөр батлах тухай 2015-2020	38	Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн аймаг, орон нутгийн хөгжлийг эрчимтэй урагшлуулах, нийгэм эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэнээ ажилтай, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой болгох, зохистой зөв хэрэглээнд төлөвшүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх бодлогыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэхэд стандартчиллын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хамтын "нэгдсэн удирдлага"-ыг хэрэгжүүлэх	
44.	Боловсролын олон нийтийн зөвлөл байгуулах тухай	44	Зорилтот бүлгийн хүүхдүүдийг судлан сонгох, тэдгээр хүүхдүүд болон гэр бүл, орчны нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох, хяналт үнэлгээг тогтмол хийх, хүүхдүүдийн боловсролын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дотоод нөөц бололцоог ашиглан санаачлан хэрэгжүүлэх ...	
45.	Хөндлөнгийн хяналтын үйл ажиллагааны зардлын хэмжээ тогтоох тухай	49	Техник хяналтын зардлын 20 хувийг иргэний хяналтын багийн үйл ажиллагаанд зарцуулах	
46.	Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай 2015-2024 он	53	Хүүхэд бүрийг үл хайхрах, хүчирхийлэх, аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, орон нутгийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх	

47.	Журам шинэчлэн батлах тухай	68	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам	
48.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн талаар авах арга хэмжээний тухай	72	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2016				
49.	Цахим тоглоомын газрын үйл ажиллагаанд хяналт тавих тухай	12	Аймгийн нутаг дэвсгэрт үйл жиллагаа явуулж буй цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудаас тавих хяналтыг сайжруулах зорилгоор	
50.	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг 2016-2018 оны нэгдсэн стратеги төлөвлөө батлах тухай	17	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг 2016-2018 оны нэгдсэн стратеги төлөвлөө	
51.	Журам батлах тухай	23	Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын амжилтыг үнэлэх, урамшуулал олгох журам	
52.	Хураамжийн хэмжээг тогтоох тухай	27	Тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд саатуулагдсан тээврийн хэрэгслээс хураах хураамжийн хэмжээ	
53.	Дүрэмд нэмэлт оруулах тухай	34	Арвайхээр тохиожилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрэмд	
54.	Журам батлах тухай	39	Мэргэжлийн баг, түүний ажиллах журам	
55.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	54	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журамд	
56.	Журамд өөрчлөлт оруулах тухай	60	Орон нутгийн өмчийн газарт холбогдох журмууд	
57.	Журам батлах тухай	61	"School police"	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ-2017				
58.	Журам батлах тухай	26	Аддиктологийн баг, Мэргэжлийн багийн ажлын үр дүнг үнэлж, дүгнэх	
59.	Орон нутгийн өмчит компани байгуулах тухай	37	ХАА-н гаралтай мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох	
60.	Адил боломж хөтөлбөр	38	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг эрүүл хүүхдийн адил тэгш хөгжүүлэх оролцуулах боломжоор хангах	
61.	Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 2017-2020 он	40	Соёлын үйлдвэрлэл: Үндэсний болон орон нутгийн соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг аймаг, бүс, улсын хэмжээнд нийтэд сурталчлан таниулах	
62.	Шатар хөтөлбөр батлах тухай	41	Аймгийн хэмжээнд шатрын спортыг хөгжүүлэх	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР